



БУЛГАН АЙМГИЙН БҮРЭГХАНГАЙ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 11/03

Дархан баг

Сумын Засаг даргын
2024-2028 оны үйл ажиллагааны
“Хөгжлийг түүчээлье” хөтөлбөрийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5, 35.1.8, 48 дугаар зүйлийн 48.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ес дэх удаагийн сонгуулийн ээлжит II хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Бүрэгхангай сумын Засаг даргын 2024-2028 оны “Хөгжлийг түүчээлье” үйл ажиллагааны хөтөлбөрийг 1 дүгээр, шалгуур үзүүлэлтийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сумын Засаг даргын 2024-2028 оны “Хөгжлийг түүчээлье” үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг сумын Засаг дарга (Э.Эрдэнэбулган)-д даалгасугай.

2.1. Сумын Засаг даргын 2024-2028 оны “Хөгжлийг түүчээлье” үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн үндсэн чиглэл, зорилт, арга хэмжээг жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл, улс, орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх;

2.2. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан баталж, хөтөлбөрийн биелэлтийг хагас жил тутамд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;

2.3. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй хамтран ажиллах.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (И.Ичинхорлоо)-д үүрэг болгосугай.



**БҮРЭГХАНГАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАХ “ХӨГЖЛИЙГ ТҮҮЧЭЭЛЬ”
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

Бүрэгхангай сумын Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа Алсын хараа 2050 үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон бодлогын баримт бичгийг үндэслэн боловсрууллаа.

Хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааг аймгийн Засаг даргын Булганы сэргэлт үйл ажиллагааны хөтөлбөрт тулгуурлан зорилтоо тодорхойллоо. Мөн аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны сонгуульд оролцсон Монгол Ардын нам, Ардчилсан намын мөрийн хөтөлбөр, төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд, олон нийтийн саналд үндэслэсэн болно.

Тухайлбал иргэд, малчид, өөр аймаг, суманд ажиллаж амьдарч байгаа оюутан, залуусын саналыг цахимаар 73 санал, цаасаар 387 санал нийт 460 санал ирүүлснийг хөтөлбөрийн төсөлдөө тусгалаа.

Хөтөлбөрийн зорилго нь **“САНААЧИЛГАТАЙ ИРГЭН, САЙН ЗАСАГЛАЛ, САЙХАН АМЬДРАЛЫГ** цогцлоосон, орон нутагтаа ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлэх”-д оршино гэж тодорхойллоо.

Үйл ажиллагааны хөтөлбөр нь 4 үндсэн чиглэлийн хүрээнд 23 бүлэг, 41 зорилт, 123 хэрэгжүүлэх арга хэмжээ тусгаж төрийн залгамж чанар, бодлогод суурилсан иргэдийн хэрэгцээнд нийцэх ажил, арга хэмжээг төлөвлөлөө.

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Сум орон нутгийн онцлог, хүн амын амьдралын хэв маяг, хэрэгцээ шаардлага, эрүүл мэнд, боловсролын түвшинд нийцсэн бодлого, шийдвэрийг гарган хэрэгжүүлж, өрх, гэр бүлийн хөгжилд чиглэсэн эрүүл, боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

Эрүүл мэнд:

Өнөөгийн нөхцөл байдал:

Эрүүл мэндийн төвд 2 эмч, 4 сувилагч, 7 эмнэлгийн мэргэжилтэн, 6 эмнэлгийн ажилтан анхан шатлалын тусламж үйлчилгээг давхардсан тоогоор 6361 хүн амд үзүүлсэн байна.

Хүн амын дунд эрт илрүүлэх үзлэгийг нас, хүйсийн онцлогт тохируулан зохион байгуулж, нийт хүн амын 80.3 хувийг хамруулаад байна. Эрт илрүүлэхийн үзлэгийн үр дүнгээс харахад хүүхдийн дунд шүд цоорох өвчлөл 90 хувьд илэрч, хүн амын дунд зүрх судасны болон амьсгалын тогтолцоо, хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөл зонхилон тохиолдож байна.

Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаанд сүүлийн 5 жилийн байдлаар элэгний хорт хавдрын нас баралт нийт нас баралтын 52,9 хувийг эзэлж байна.

Эрүүл мэндийн төв 2024 оны 12 дугаар сарын байдлаар 2 эмч, 1 сувилагч, 1 эмнэлгийн бусад мэргэжилтэн шаардлагатай бөгөөд боловсон хүчний хангалт 85%-тай байна.

Эрүүл мэндийн төвийн барилга байгууламжийн хувьд 1994 онд ашиглалтад орсон насжилт өндөртэй, эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга шинээр барих, түргэн тусламжийн автомашиныг шинэчлэх шаардлагатай байна.

1.1. Хүн амын эрүүл мэндийн зөв дадлыг хэвшүүлж, дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.

1.1.1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

1.1.1.1. Эрүүл амьдралын хэв маягийг дэмжиж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэн, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэхийн үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

1.1.1.2. Хүн амын дунд зонхилон тохиолдох өвчлөлийг бууруулна.

1.1.2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.1.2.1. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай техник, тоног, төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлж, барилга байгууламжийн өргөтгөл, шинэчлэлийг хийж, стандартын шаардлагад нийцүүлнэ.

1.1.2.2. Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болсон хавдрын өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэхэд чиглэсэн "Эрүүл Булган" хөтөлбөрийг дэмжинэ.

1.1.3. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, чадавхыг нэмэгдүүлнэ.

1.1.3.1. Эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, сургах, туршлага судлуулах замаар эрүүл мэндийн төвийн хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэн, залгамж халааг бэлтгэнэ.

1.1.3.2. Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны нийгмийн баталгааг сайжруулна.

Боловсрол:

Өнөөгийн нөхцөл байдал:

2024-2025 оны хичээлийн жилд 2 сургалтын байгууллага сургалтын үйл ажиллагаа зохион байгуулж байгаа бөгөөд сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 13 багш, 7 ажилтан, 166 хүүхэд, ерөнхий боловсролын сургуульд 24 багш, 4 удирдах ажилтан, 20 үйлчилгээний ажилтан, 378 суралцагчтайгаар сургалтын үйл ажиллагааг явуул байна. Ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багшийн хангалт 85,7%-тай байна.

Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 2024-2025 оны хичээлийн жилд 72 хувь, ерөнхий боловсролын хамран сургалт 62 хувьтай байгаа боловч хамран сургалтын хувь жилээс жилд буурах төлөвтэй байгаа нь шилжилт хөдөлгөөнтэй холбоотой байна.

Цэцэрлэгийн хуучин барилгад засвар хийх шаардлагатай. Ерөнхий боловсролын сургуулийн хувьд ахлах ангийн хамран сургалт бага, зарим анги, танхимыг засварлан тохижуулах, шинээр спорт заалыг барих шаардлага байна.

Элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст оноог аймгийн дунжаас бууруулахгүй байх. (Булган аймгийн 2024 оны ЭЕШ-ын Х.О.Д - 509)

1.2. Боловсролын байгууллагын хөрөнгө оруулалт, хүний нөөцийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.2.1.Сургууль, цэцэрлэг, дотуур байрны урсгал засвар, спорт заалны шинэ барилга байгууламжийн хүчин чадал, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлж, сургалтын тохируулгат орчныг бий болгоно.

1.2.1.1.Багш, сурагчдын сурч, хөгжих орчин нөхцөлийг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шийдвэрлэн хүүхдэд ээлтэй сургалтын орчныг бүрдүүлнэ.

1.2.1.2.Сургууль, цэцэрлэгийн барилга, байгууламжийн шинэчлэл засварын ажлыг хэрэгжүүлнэ.

1.2.2.Багш, удирдах ажилтны мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлнэ.

1.2.2.1.Суралцагчийн хөгжлийн хэрэгцээ шаардлагыг хангасан, чадварлаг багшийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ.

1.2.2.2.Багш нарын нийгмийн баталгааг хангаж, сум орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах таатай орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2.3.Суралцагсдын сурлагын ахиц амжилтыг дээшлүүлнэ.

1.2.3.1.Оюунлаг иргэнийг бэлтгэх зорилгоор математик, мэдээлэл зүй, англи хэлний судлагдахууныг нэмэгдүүлнэ.

1.2.3.2.Сургуулийн өмнөх боловсролд шинжлэх ухаан, инженерчлэл, математик, технологи, уран бүтээл хийх, амьдрах ухаан, ур дүй хөгжүүлэх "STEAM" үйл ажиллагааг дэмжинэ.

1.2.3.3.Бага боловсролыг дэмжих "Амжилтын гараа" хөтөлбөрийг дэмжинэ.

1.2.3.4.Элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст оноог аймгийн дунджаас дээгүүр түвшинд хүргэнэ. (Булган аймгийн 2024 оны ЭЕШ-ын Х.О.Д - 509)

1.2.3.5.Жил бүр 12 дугаар анги төгсөгчдөөс суманд нэн шаардлагатай мэргэжлээр гадаад, дотоодын их, дээд сургуульд суралцах боломжийг бүрдүүлэн тэтгэлэгт хөтөлбөрийг дэмжинэ.

1.2.3.6.Суралцагчдын сонирхол, авьяас чадварыг нээн хөгжүүлэх секц, дугуйлангийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.

Гэр бүл, хүүхэд, залуучууд:

Өнөөгийн нөхцөл байдал:

Сумын хэмжээнд 0-18 насны 541 хүүхэд, 15-35 насны 448 залуучууд байна. Үүнээс хагас өнчин-22, бүтэн өнчин-4 хүүхэд байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг энэ онд 2 бүртгэгдэж, өмнөх онтой харьцуулахад 2 дахин, гэр бүлийн хүчирхийллийн зөрчил энэ онд 6 бүртгэгдэж өмнөх оноос 1 нэгж буюу 16,7 хувиар тус тус өссөн байна.

Сумын хэмжээнд 9 төрлийн дугуйлан, секцэд давхардсан тоогоор 115 хүүхэд хамрагдаж байна.

1.3.Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил хамгааллын тэгш оролцоог хангана.

1.3.1.Хүүхэд, залуучуудын хөгжил оролцоог нэмэгдүүлнэ.

1.3.1.1.Хүүхэд, өсвөр үе, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, идэвх, оролцоог дэмжсэн "Залуусын хөгжил" хөтөлбөрийг дэмжинэ.

1.3.1.2.Иргэн, хувийн хэвшлийн санаачилгатай хүүхдийн хөгжил, оролцоог дэмжсэн секц дугуйлан, сургалтын төвүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

1.3.2.Залуу гэр бүлрүү чиглэсэн амьдрах олон талт таатай нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.

1.3.2.1.Гэр бүлийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн арга хэмжээг нэмэгдүүлнэ.

1.3.2.2.Залуу гэр бүлийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

1.3.2.3.Хүүхэд, гэр бүл, залуучуудын хэрэгцээ шаардлагыг хангахуйц урлаг, спортын барилга байгууламжийг нэмэгдүүлнэ.

Хөдөлмөр эрхлэлт:

Өнөөгийн нөхцөл байдал:

Сумын нийт хүн амын 64,3 хувийг хөдөлмөрийн насны хүн ам эзэлж байгаа бөгөөд үүнээс 53,2 хувь нь ажиллах хүч, 25 хувь нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна.Сумын ажилгүйдлийн түвшин сүүлийн 3 жил 0.06-аас 0.04 хувь хүртэл буурсан эерэг үзүүлэлттэй байна.

1.4.Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, ажилгүйдлийн түвшинг бууруулна.

1.4.1.Өрхийн орлогыг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжинэ

1.4.1.1.Орон нутгийн онцлог, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх "Чадварлаг мэргэжилтэн" хөтөлбөрийг дэмжинэ.

1.4.1.2.Үйлдвэрлэл, бүтээн байгуулалт, төсөл хөтөлбөрийн хүрээнд байнгын болон улирлын чанартай ажлын байрыг бий болгоно.

1.4.1.3.Халамжаас хөдөлмөрт шилжиж, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийг ажлын байраар хангана.

Нийгмийн халамж, хамгаалал:

Өнөөгийн нөхцөл байдал:

Сумын хэмжээнд 962 өрх буюу нийт өрхийн 2,1 хувийг амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрх эзэлж байна. Өрх толгойлон амьдарч байгаа 82 иргэн байна. Нийт хүн амын 14,2 хувийг ахмад настан, 1,9 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн эзэлдэг.

1.5.Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулна.

1.5.1.Зорилтот бүлгийн иргэдийн амьдрах чадварыг сайжруулна.

1.5.1.1.Зорилтот бүлгийн өрхийн гишүүдийн хөгжил, оролцоог хангахад чиглэсэн хөтөлбөр арга хэмжээг дэмжинэ.

1.5.1.2.Нийгмийн халамж, тусламж, үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлнэ.

1.5.1.3.Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлж, төрийн байгууллагуудын ажилтнуудын эерэг харилцаа, хандлагыг төлөвшүүлнэ.

Биеийн тамир, спорт:

Өнөөгийн нөхцөл байдал:

Сумын хэмжээнд өсвөрийн багийг спортын 6 төрлөөр тогтмол 58 тамирчин хичээллэж, мэргэжлийн 2 багш, дасгалжуулагч бэлтгэл, сургуулалтыг удирдан зохион байгуулж байна.

Үндэсний спортын сурын харваа, бөхийн төрлөөр давхардсан тоогоор 40 хүүхдүүд хичээллэж байна. 2024 онд иргэдэд үйлчлэх биеийн тамирын спортын хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд шинээр фитнесийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлсэн. Тив дэлхий, улс, бүс, аймаг, сумын тэмцээнүүдэд амжилт гаргасан тамирчдад мөнгөн дэмжлэгийг үзүүлж ажилласан.

1.6.Хүн амын эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжинэ.

1.6.1.Иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх идэвхийг өрнүүлж, ээлтэй орчныг бүрдүүлнэ.

1.6.1.1.Иргэдэд үйлчлэх стандартын шаардлага хангасан зам талбай, заал танхимыг нэмэгдүүлнэ.

1.6.1.2.Хүн амын эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулна.

1.6.2.Өвлийн болон үндэсний спортыг хөгжүүлж, спортын амжилтыг нэмэгдүүлнэ.

1.6.2.1.Спортын холбоо, клуб, иргэдтэй хамтран төрөл бүрийн спортыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

1.6.2.2.Үндэсний спорт, багийн спортоор хичээллэгсдийн тоог нэмэгдүүлнэ.

1.6.2.3.Тив дэлхийн болон улс, бүс, аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцсон тамирчдад дэмжлэг үзүүлэх, урамшууллыг тогтолцоог хэрэгжүүлнэ.

1.6.2.4.Өвлийн спортын төрлийг хөгжүүлж, спортоор хичээллэгсдийн тоог нэмэгдүүлнэ.

Соёл, урлаг:

Өнөөгийн нөхцөл байдал:

Соёлын төв 5 албан хаагч соёлын үйлчилгээг үзүүлж байна. Үүнээс соёлын төвийн эрхлэгч-1, дуу, хөгжмийн багш-1, бүжгийн багш-1, номын санч-1, үйлчлэгч-1 орон тооны хангалт 100 хувьтай, мэргэжлийн боловсон хүчний хангалт 75 хувьтай байна

Соёлын төвийн барилгыг 2025-2026 онд ашиглалтад хүлээн авна. 2024 онд улс, аймгийн хамгаалалтад байдаг 21 дэсийн 159 дурсгал байдаг ба аймгийн хамгаалалтад 4 дурсгалыг авсан. Сумын Орон нутаг судлах танхимд 64 ширхэг үзмэр хадгалагдаж байна.

1.7.Соёлын байгууллагын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.7.1.Соёлын салбарын мэргэжилтэй боловсон хүчний хангалтыг нэмэгдүүлнэ.

1.7.1.1.Соёлын төвийн албан хаагчдыг мэргэшүүлэх, давтан сургах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

1.7.2.Соёлын төвийн орчин нөхцөл, техник, тоног төхөөрөмжийг сайжруулна.

1.7.2.1.Соёлын төвийн шинэ барилгыг ашиглалтад хүлээн авна.

1.7.2.2.Соёлын төвийн техник, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж, шаардлагатай хувцас хэрэглэлээр хангана.

1.7.2.3.Музей, Номын сангийн фонд баяжилт хийж, цахим номын сан, явуулын номын сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1.7.3.Соёлын биет болон биет бус өвийг хадгалан хамгаалж, өвлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

1.7.3.1.Соёлын биет болон биет бус өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, өвлөн уламжлуулах ажлыг үе шаттай зохион байгуулна.

1.7.3.2.Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжинэ.

1.7.4.Бүх нийтийн соёлын боловсролыг хөгжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

1.7.4.1.Хүн амын өнцлөг хэрэгцээнд нийцсэн соёлын үйл ажиллагааг зохион байгуулна.

1.7.4.2. Хүүхэд залуучуудын соёл урлагийн авьяасыг нээн илрүүлэх, хөгжүүлэх ажлыг зохион байгуулна.

1.7.4.3. "Амьд хөгжим" хөтөлбөрийг дэмжинэ.

Аялал жуулчлал:

Өнөөгийн нөхцөл байдал:

Сумын хэмжээнд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг 2 аж ахуйн нэгж бүртгэгдсэнээс 1 аж ахуйн нэгж идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

1.8. Орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

1.8.1. Орон нутгийн онцлогт түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

1.8.1.1. Аялал жуулчлалын зам дагуу амрах өртөө, зорин очих газруудад ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг байгуулна.

1.8.1.2. Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийг чадавхжуулж, үйлчилгээ, стандартын шаардлагад нийцүүлнэ.

1.8.1.3. "Жорлонгоо өөрчилъе-Хогоо шийдье" уриан дор байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

1.8.1.4. Аялал жуулчлалын бүсэд орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг худалдаалах нөхцөлийг бүрдүүлнэ.

1.8.1.5. Тусгай сонирхлын болон соёлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

1.8.1.6. Өвлийн спортод тулгуурласан орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Хөдөө аж ахуй, уул уурхай, газар тариалангийн үйлдвэрлэлийг хослон хөгжих, үр ашгийг нэмэгдүүлж, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.

Эдийн засаг:

Өнөөгийн нөхцөл байдал

Сумын хэмжээнд 147 бүртгэлтэй аж ахуй нэгж, байгууллага байгаагаас үйл ажиллагаа явуулж байгаа 27 аж ахуйн нэгж байна. Эдгээр аж ахуй нэгж, байгууллагаас нийгмийн хариуцлагын гэрээний хөрөнгө 438,2 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 903,8 сая төгрөг, малын тоо толгойн албан татвар 205,9 сая төгрөг төсвийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

2.1. Хөдөө аж ахуй, уул уурхай, газар тариалангийн үйлдвэрлэлийг хослон хөгжих, үр ашгийг нэмэгдүүлэх зарчмаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.

2.1.1. Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

2.1.1.1. Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг оновчтой тодорхойлж, төсөл хөтөлбөрүүдийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

2.1.2. Татварын бааз суурь, төсвийн орлогыг нэмэгдүүлнэ.

2.1.2.1. Татварын шинэчлэлийн хүрээнд татварын бодлогыг хэрэгжүүлнэ.

2.1.2.2. Татвар төлөгчийн татварын боловсролыг дээшлүүлнэ.

2.1.2.3. Цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.1.3. Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэн, үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.

2.1.3.1. Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүн, орон нутгийн худалдаа эрхлэгчдийг төрийн худалдан авалтаар дэмжинэ.

Уул уурхай:

2.2. Хариуцлагатай уул уурхайг дэмжинэ.

2.2.1.Орон нутагт үр өгөөжтэй уул уурхайг дэмжиж, эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна.

2.2.1.1.Уул уурхайн ААН-үүдийн нөхөн сэргээлтийн ажлыг чанаржуулж, хяналтыг сайжруулна.

2.2.1.2.Уул уурхайн нөлөөгөөр эвдэгдсэн орон нутгийн газруудад нөхөн сэргээлт хийлгэх боломжит газруудад тэжээлийн ургамал тариалахыг дэмжинэ.

2.2.1.3.Уул уурхайн нийгмийн хариуцлагаар байгаль орчин, нийгэм, эдийн засаг, дэд бүтэц, боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, хүний нөөцийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хамтын ажиллагааг сайжруулж үр дүнд хүргэнэ.

Зам тээвэр:

Өнөөгийн нөхцөл байдал:

2018 онд сумын төвийн 1,8 км, 2020 онд 1 км цемент бетонон хучилттай авто зам, 2024 онд 0,4 км асфальтан хучилттай авто замыг тус тус ашиглалтад хүлээн авсан байна.

2.3.Сумын авто зам, замын байгууламжийг нэмэгдүүлнэ.

2.3.1.Сумын авто зам, замын байгууламжийг өргөтгөж, шинэчилнэ.

2.3.1.1.Сумын төвийн 4,5 км авто замын бүтээн байгуулалтыг үргэлжлүүлнэ.

2.3.1.2.Сумын төвийн авто зогсоол, үерийн ус зайлуулах далан шуудууг шинээр байгуулах, 5-р хорооны гүүрэн гарц байгуулна.

2.3.1.3.Нийтийн эзэмшлийн зам талбайг засаж сайжруулна.

2.3.1.4.Сумын төвийг аймгийн төвтэй хатуу хучилттай авто замаар холбох зураг төсвийг хийлгэж замын ажлыг эхлүүлнэ.

Хөдөө аж ахуй:

Өнөөгийн нөхцөл байдал:

Сумын хэмжээнд малтай 699 өрх, мал бүхий 202 өрх байна. 2024 оны жилийн эцсийн урьдчилсан байдлаар 263,569 толгой мал тоолуулсан бөгөөд үүнээс тэмээ-174 адуу-25,718 үхэр-28,188 хонь-126,563 ямаа-82,926.

2024 онд мал эмнэлгийн гэрчилгээнд хяналт тавин худалдааны зориулалтаар нийт 5,761 толгой малыг 1 тэрбум 418 сая төгрөгөөр борлуулалт хийж, нийт 91,211кг махыг 821,7 сая төгрөгөөр зах зээлд борлуулсан байна.

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд давхардсан тоогоор 472,637 толгой малыг хамруулсан. Улаан буудай 1942 га талбайд тариалж 2978 тн ургац, тосны ургамал 1055 га талбайд тариалж 528 тн ургац, тэжээлийн ургамал 266 га талбайд тариалж 645 тн, төмс 3 га талбайд тариалж 8.5 тн ургац, хүнсний ногоо 2,51 га талбайд тариалж 7,174 тн ургац хураан авсан.

2.4.Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

2.4.1.Мал аж ахуйн салбарын тогтвортой үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

2.4.1.1.Өндөр ашиг шимтэй малын нийт сүрэгт эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлнэ.

2.4.1.2.Бэлчээрийг нөхөн сэргээх, сэлгэх, хамгаалах, усжуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.4.1.3.Нутгийн онцлогт тохирсон мал аж ахуйн бодлогыг хэрэгжүүлнэ.

2.4.1.4.Хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийг бэлтгэх, малчдыг чадавхжуулна.

2.4.1.5.Хөдөө аж ахуйн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө-Сэргэлт" хөтөлбөрийг дэмжинэ.

2.4.1.8.Малын үүлдэр угсааг сайжруулах зорилгоор үржлийн нэгжүүдийг бодлогоор дэмжинэ.

2.4.2. Малын өвчлөлөөс урьдчилан сэргийлнэ.

2.4.2.1.Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлнэ.

2.4.2.2.Мал эмнэлгийн салбарын чанар хүртээмж, үр дүнг сайжруулна.

2.4.3.Газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, хөдөө аж ахуйн зохистой дадлыг нэвтрүүлнэ.

2.4.3.1.Тариалангийн тогтвортой хөгжлийг дэмжих "Атар-4" аяныг дэмжинэ.

2.4.3.2.Газар тариалангийн атаршсан талбайг эргэлтэд оруулж, үр тариа, тэжээлийн ургамал тариалалтыг нэмэгдүүлнэ.

2.4.3.3.Тариалангийн талбайг хөрсний элэгдэл эвдрэлээс хамгаалж, үржил шимийг сайжруулна.

2.4.3.4.Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлж, хүнсний ногооны агуулах, зоорийг шинээр барьж орон нутгийн хэрэгцээгээ хангана.

Байгаль орчин:

Өнөөгийн нөхцөл байдал:

Бүрэгхангай сумын ойн сан 25,548га, хөнөөлт шавжинд нэрвэгдсэн талбай 1,443га, шатсан ой 11,949га байна. 2023 онд аймгийн Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр ойн хөнөөлт шавьж, өвчний устгалыг онгоцны аргаар 1000 га-д хийгдсэн. 2024 онд ойн хөнөөлт шавьж өвчний судалгааны ажил 12,000 га-д хийгдсэн байна. 2020-2024 онд 360 га талбайгаас мод бэлтгэсэн бол үүний 300 орчим га талбайг ойн нөхөрлөл, бүлүүд цэвэрлээд байна. Уул уурхайн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 9 ААН байгаа бөгөөд 2020-2024 онд техникийн нөхөн сэргээлт нийт 210,7 га, биологийн нөхөн сэргээлт нийт 192,6 га-д хийж аймгийн ажлын хэсэгт хүлээлгэж өгсөн. Мөн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд 4 жилийн хугацаанд орон нутгийн эвдэрч эзэнгүй орхигдсон 100 орчим га талбайг нөхөн сэргээгээд байна. Цаашид нөхөн сэргээлтийн ажлыг үе шаттайгаар хийх шаардлагатай бөгөөд сумын хэмжээнд уул, уурхайн нэгж, айл өрх, албан байгууллагууд нийт 68,065 мод, бутыг тарьсан.

2.5.Байгалийн нөөц баялгийг хамгаалж, нөхөн сэргээх, зохистой ашиглаж, байгалийн унаган төрхийг хадгална.

2.5.1.Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг өргөтгөнө.

2.5.1.1.Сумын хэмжээнд орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг нэмэгдүүлнэ.

2.5.1.2.Биологийн төрөл зүйл (амьтан, ургамал)-ийг хамгаалж, өсгөн үржүүлж зохистой ашиглана.

2.5.2. Усны нөөцийг хамгаална.

2.5.2.1.Усны сан (булаг шанд, гол горхи, рашаан) бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, усан хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс тогтоож, дэглэмийг мөрдүүлнэ.

2.5.2.2.Хүн амын баталгаат усан хангамжийг сайжруулна.

2.5.3.Ойн зохистой ашиглалт, хамгаалалтыг нэмэгдүүлнэ.

2.5.3.1. Ойн сангийн даацад тохируулан мод, ойн дагалдах баялгийг ашиглана.

2.5.3.2. Ойг хамгаалах, нөхөн сэргээх замаар ойн сан бүхий газар мод тарих ажлыг зохион байгуулах, чанаржуулах, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг жил бүр нэмэгдүүлэх.

2.5.3.3. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд жил бүр мод, бут, сөөг тарьж ургуулна.

2.5.3.4. Цөлжилттэй тэмцэх, сэргийлэх, сааруулах зорилгоор ойн хамгаалалтын зурвас байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.5.3.5. Доройтсон ойг нөхөн сэргээх, зохистой ашиглах зорилгоор нөхөрлөл, аж ахуйн нэгжтэй хамтын ажиллагааг сайжруулж ойн бүлүүдийг дэмжиж ажиллана.

2.5.4. Орчны бохирдлыг бууруулна.

2.5.4.1. "Цэвэр орчин-Цэмцгэр Бүрэгхангайчууд" аяныг хэрэгжүүлнэ.

2.5.4.2. Айл өрхийг хог ангилан ялгах хогийн саваар үе шаттайгаар хангана.

2.5.4.3. Хог хаягдлын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

2.5.4.4. Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож, хог хаягдал ангилан ялгах байрыг ашиглалтад оруулах ажлыг дэмжинэ.

2.5.4.5. Хог хаягдлыг ангилан ялгах, боловсруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.

2.5.4.6. Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудыг байгальд ээлтэй, стандартын шаардлагад нийцсэн эко нойлтой болгох ажлыг дэмжинэ.

ГУРАВ. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ

Өмчлөлийн газар олголтыг 25 хувьд хүргэх, инженерийн дэд бүтцийн өргөтгөл, шинэчлэлийг хийж, орон нутагт барилгажих боломжийг бүрдүүлж, иргэдийн сэтгэл ханамжтай амьдрах орчныг бүрдүүлнэ.

Хот байгуулалт, газрын харилцаа, барилга, дэд бүтэц:

Өнөөгийн нөхцөл байдал:

Төв суурингийн 23км 0,4кВт цахилгаан дамжуулах сүлжээ, 1,5 км цементэн хучилттай авто зам, 5721м гудамжны гэрэлтүүлэг хийгдсэн байна. Цэвэр ус, дулаан хангамжийн 4874 метр, бохирын 2225 метр магистрал шугам сүлжээний ажил хийгдэж, Дулааны нэгдсэн төв байгуулан төр, төсвийн байгууллага, аж ахуй нэгж, айл өрхүүд төвлөрсөн халаалтад холбогдоод байна. Цэвэр усан хангамжийн байгууламж, цэвэршүүлэх байгууламжийн асуудлыг бүрэн шийдвэрлэж дэд бүтэц, инженерийн шугам сүлжээгээрээ аймагтаа тэргүүлэх сум болж барилга, орон сууцжих нөхцөл 100 хувь бүрдсэн. Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын төвийн хөгжлийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт хийнэ. 2024 оны жилийн эцсийн байдлаар 1324 иргэнд газар олголт хийгдэж, өмчлөлийн зориулалтаар 376 иргэнд 51,97 га, эзэмшлийн зориулалтаар 933 иргэнд 6029,1 га, ашиглалтын зориулалтаар 15 иргэнд 203 га газар олгосон байна.

3.1. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан эрх зүйн харилцаа үүсгэх, төлөвлөлтийн хэрэгжилтийг нэмэгдүүлнэ.

3.1.1. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу газар олголтыг газрын хэрэгцээт байдлын үнэлгээнд нийцүүлэн олгоно.

3.1.1.1.Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийнэ.

3.1.1.2.Сумын хэмжээнд геодезийн цэг тэмдэгийн тооллого зохион байгуулж бүртгэлжүүлнэ.

3.1.1.3.Газар зохион байгуулалт, хот төлөвлөлт, газрын кадастрын мэдээллийн цахим системээр газар олголтыг ил тод болгон, хяналтыг сайжруулна.

Барилга, хот байгуулалт:

3.2.Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тодотгож, хэрэгжүүлэх.

3.2.1.Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд дэд бүтцийг цогцоор нь шийдвэрлэнэ.

3.2.1.1.Сумын төвийн ногоон байгууламж, гэр хорооллын гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.

3.2.1.2.Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд орон сууцжуулах болон түрээслээд өмчлөх "Бүрэгхангай-Орон сууц" төсөл хэрэгжүүлнэ.

3.2.1.3.Сумын ус, дулаан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийн шугам сүлжээнд өргөтгөл хийж, шат дараатай нэмэгдүүлнэ.

3.2.1.5. Шаддүвдаржаалин хийдийг цэвэр бохир, дулаанд холбох.

3.2.1.6. Үүрэн холбооны сүлжээнд холбогдоогүй газар нутгийг сүлжээнд хамруулна.

Эрчим хүч:

3.3.Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг хангуулна.

3.3.1.Эрчим хүчний эх үүсвэр, дэд станц, тоноглол, шугам сүлжээний найдвартай байдлыг хангуулна.

3.3.1.1.Хишиг-Өндөр, Бүрэгхангай чиглэлийн 35квт цахилгаан дамжуулах сүлжээний зураг төсөв хийж, шинэчлэн байгуулж эрчим хүчний эх үүсвэрийн найдвартай байдлыг хангана.

3.3.1.2.Сумын төвийн хорооллуудын эрчим хүчний шугам сүлжээ, дэд станцын тоног төхөөрөмжийн өргөтгөл шинэчлэлийн ажлыг хийнэ.

Үйлдвэрлэл, үйлчилгээ:

Өнөөгийн нөхцөл байдал:

Сумын хэмжээнд 8 нэрийн дэлгүүрийн үйлчилгээ – 5, зочид буудал, зоогийн газрын үйлчилгээ - 3, аялал жуулчлал амралтын газар-2 аж ахуй нэгж тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Худалдааны төвд малын эмийн сан-1, цайны газар-1, бэлэн хувцасны худалдаа-3, торго бөс бараа-3, оёдолын үйлчилгээ-5 иргэн, халуун ус-2, үсчин-1, нийтийн ОО-1, дугуй засвар-2 тус тус үйлчилгээ явуулж байна.

Хоршоог хөгжүүлэх сангаас 2024 онд 3 хоршоонд 100 сая төгрөгийн зээлийг Малын эмийн сан, мал эмнэлэгийн үйлчилгээ, фермерийн аж ахуй, өвлийн хүлэмжийн үйл ажиллагааны чиглэлээр олголоо.

Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 15 хоршооны 71 өрхөд 2 тэрбум 857 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж хөдөө аж ахуйн салбараас энэ оны байдлаар 167,6 сая төгрөгийн дотоодын худалдан авалт хийгдсэн.

Орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан орон нутгийн нөөцөд түшиглэсэн мах, оаивар бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх шаардлагатай байна.

3.4. Орон нутгийн нөөцөд түшиглэсэн үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжин, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

3.4.1. Жижиг, дунд, үйлдвэрлэлийг хөгжүүлж, хувийн хэвшил, хоршоодыг дэмжинэ.

3.4.1.1.Орон нутгийн түүхий эдийн нөөцөд тулгуурласан мах, дайвар бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, малын тэжээлийн үйлдвэрлэлийг эхлүүлж, бодлогоор дэмжиж ажиллана.

3.4.1.3.Үйлдвэр, үйлчилгээ байгуулахад хөрөнгө оруулалтын ээлтэй орчныг бүрдүүлнэ.

3.5.Үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.5.1.Үйлдвэрлэл, үйлчилгээ, хүнсний стандарт хангалт, зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

3.5.1.1."Үйлдвэрлэлийн сэргэлт" хөтөлбөрийг дэмжинэ.

3.5.1.2.Бизнес, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхжуулж, дэмжлэг үзүүлнэ.

3.5.1.3.Үйлчилгээний эрүүл ахуй, хүнсний чанар, аюулгүй байдлын хяналтыг сайжруулна.

3.5.1.4.Үйлчилгээний төвийг өргөжүүлж, ахуйн үйлчилгээний төрлийг нэмэгдүүлнэ.

ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Төрийн үйлчилгээнд үр нөлөөтэй цахим засаглалыг хэрэгжүүлэн, мэргэшсэн ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлж, иргэдийн амар тайван, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

Хууль, эрх зүй:

Өнөөгийн нөхцөл байдал:

Сумын хэмжээнд 2024 онд 12 гэмт хэрэг бүртгэгдэж, 5-аар буюу 29 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 8 чиглэлд 27 ширхэг камерыг байршуулан хяналт тавин ажиллаж байна.

4.1.Амар тайван, аюулгүй орчныг бий болгоно.

4.1.1.Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэмэгдүүлнэ.

4.1.1.1.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх "Амар тайван Булган" хөтөлбөрийг дэмжинэ.

4.1.1.2.Сумын төвийн хэмжээнд ухаалаг камерийг нэмэгдүүлж, ногоон бүс болно.

4.1.1.3.Цагдаагийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулна.

4.1.1.4.Мэргэжлийн байгууллагатай хамтран нэгдсэн болон тусгай, хэсэгчилсэн ажил арга хэмжээг зохион байгуулж, хамтран ажиллана.

4.2.Гамшгийн эрсдэлийг даван туулах чадварыг нэмэгдүүлнэ.

4.2.1.Орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулна.

4.2.1.1.Болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, сэргээн босгох чадавхыг бэхжүүлж, иргэдийн боловсролыг дээшлүүлнэ.

4.2.1.2.Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг сайжруулж сургалт, дадлага зохион байгуулах, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийг ажиллах нөхцөлөөр хангаж техник, зэвсэглэмжийг нэмэгдүүлнэ.

4.2.1.3.Болзошгүй байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Батлан хамгаалах:

Өнөөгийн нөхцөл байдал:

Орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах бодлого, зорилтыг хэрэгжүүлж, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэн дайчилгааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Цэргийн албыг 7 иргэн биеэр, дүйцүүлэх 3 иргэн, мөнгөн төлбөрөөр 6 иргэн хааж байна. Цэргийн шинэчилсэн бүртгэл, орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний тодотголыг жил бүр амжилттай зохион байгуулж байна.

4.3.Иргэдийн эх орноо хамгаалах бэлтгэлжилтийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

4.3.1.Батлан хамгаалах хуулиар хүлээсэн үндсэн үүргийг хэрэгжүүлнэ.

4.3.1.1.Батлан хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлж, хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлнэ.

4.3.1.2.Орон нутгийн дайчилгааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана.

4.3.1.3.Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана.

Цахим засаглал:

4.4.Төрийн үйлчилгээг иргэдэд хурдан шуурхай, ил тод хүргэнэ.

4.4.1.Төрийн үйлчилгээг цахимжуулна.

4.4.1.1.Төрийн үйл ажиллагааны хурд, бүтээмжийг дээшлүүлж, иргэдэд түргэн шуурхай, хялбар үйлчилгээ үзүүлэх "Цахим Булган" хөтөлбөрийг дэмжинэ.

4.4.1.2.Төрийн мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллана.

4.4.1.3.Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулна

Түүхт ойг тэмдэглэн өнгөрүүлэх:

4.5.Булган аймаг байгуулагдсаны түүхт 90 жилийн ой, сумын Ерөнхий боловсролын сургууль, эрүүл мэндийн төвийн түүхэн ойг тэмдэглэн өнгөрүүлнэ.

4.5.1.Түүхэн ойн арга хэмжээнд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

4.5.1.1.Ерөнхий боловсролын сургуулийн 100 жилийн ойн арга хэмжээнд дэмжлэг үзүүлнэ.

4.5.1.2.Эрүүл мэндийн төвийн 100 жилийн ойн арга хэмжээнд дэмжлэг үзүүлнэ.

4.5.1.3. Булган аймгийн түүхт 90 жилийн ойн арга хэмжээнд дэмжлэг үзүүлнэ

Мэргэшсэн, ёс зүйтэй төрийн алба:

Өнөөгийн нөхцөл байдал:

Бүрээгхангай сумын хэмжээнд нийт 125 төрийн албан хаагчид ажилладаг. Үүнээс Төрийн захиргааны албан хаагч 19, төрийн тусгай албан хаагч 6, улс төрийн албан хаагч 7, төрийн үйлчилгээний албан хаагч 93, эдгээрээс эмэгтэй 105, эрэгтэй 20 төрийн албан хаагч байна. Төрийн албан хаагчдын шат дараатайгаар сургалтад хамруулан мэдлэг, чадварыг дээшлүүлсэн. Сумын хэмжээнд хүний нөөцийн хангалт 89.5-тай байна.

4.6.Мэргэшсэн, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлнэ.

4.6.1.Төрийн албан хаагчдын ажлын туршлага, мэдлэг чадвар, ёс зүйг дээшлүүлнэ.

4.6.1.1.Төрийн албан хаагчдыг сургалтад хамруулж, туршлага судлуулан, мэдлэг ур чадварыг дээшлүүлнэ.

4.6.1.2.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, зөрчилгүй ажиллах соёлыг хэвшүүлж, төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороодыг чадавхжуулна.

4.6.1.3.Төрийн бүх шатны байгууллагад ажиллаж буй шинэ, залуу мэргэжилтнүүдийг чадавхжуулна.

4.6.2.Төрийн албан хаагчдын нийгмийн баталгаа хангагдаж, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

4.6.2.1.Төрийн албан хаагчдад орон нутгийн төсвөөс олгох нэмэгдлийн хамрах хүрээ, хувь хэмжээг үе шаттай нэмэгдүүлж, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлнэ.

4.6.2.2.Төрийн байгууллагуудын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж, төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

Гадаад харилцаа:

4.7.Эдийн засгийн үр өгөөжтэй гадаад хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

4.7.1.Булган аймгийн Засаг дарга, түүний Тамгын газартай хамтран гадаад харилцааг хөгжүүлнэ

4.7.1.1.Гадаад улс орнуудтай нийгэм, эдийн засаг, хөдөө аж ахуй, төрийн албаны чиглэлээр хамтран ажиллах асуудлыг судалж, гадаад харилцааг хөгжүүлнэ.